



ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ЯЛТАНД ОЛГОХ УРАМШУУЛЛЫН ЭРХ ЗҮЙН МӨН ЧАНАР (ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ)



НАВААНЫ ГАНТУЛГА

ШШГС-ийн захирал, доктор, дэд
профессор, хурандаа

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн... эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох...”¹ хэмээн тусгагдсан бөгөөд энэ хүрээнд эрүүгийн, эрүүгийн байцаан шийтгэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай зэрэг олон хууль, хууль тогтоомжийн бусад актыг шинэчлэх бэлтгэл ажил эрчимтэй явагдаж байна.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийг шинэчлэх үзэл санааны хүрээнд хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны институт болох ялтанд олгох урамшууллын асуудлыг өнөөдөр мөрдөж буй үндэсний болоод ОХУ-ын Эрүүгийн ялын гүйцэтгэлийн хуулийн хүрээнд харьцуулан судалж судлаачийн дүгнэлт, саналыг илэрхийлэхээр зорилоо.

Хорих ялын зорилтыг хангахад хорих байгууллагын зүгээс ялтны сайн үйлийг сайшаан, тэдний хариуцлагын мэдрэмжийг хөгжүүлэх, засран хүмүүжих сонирхлыг хөхүүлэн дэмжих явдал онцгой ач холбогдолтой.

Харьцуулалт нь харьцуулагч зүйлүүдийн нийтлэг ба ижил төстэй, ялгаатай ба онцлог талуудыг нээн илрүүлж зүй тогтол, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан дүгнэлт, санал боловсруулах бололцоо олгодог тул энэхүү бичил судалгаанд дээрхи аргыг ашигласан болно.

¹ Монгол Улсын Их хурлын 2012 оны 09-р сарын 18-ны 37-р тогтоолын хавсралт //Төрийн мэдээлэл. УБ 2012. №36/753/ х.2242



Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай (2002 он) хуулиас	ОХУ-ын Эрүүгийн ялын гүйцэтгэлийн тухай (1997 он) хуулиас
<p>126 дугаар зүйл. Ялтныг урамшуулах</p> <p>126.1. Хорих ангийн дэг журмыг чанд сахиж, хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлж байгаа ялтныг хорих ангийн даргын шийдвэрээр дараахь хэлбэрээр урамшуулна.</p> <p>126.1.1. хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх;</p> <p>126.1.2. урьд оногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах;</p> <p>126.1.3. энэ хуульд заасны дагуу шагналын хоног олгох.</p>	<p>113-р зүйл. Хорих ял эдэлж буй ялтанд олгох урамшууллын арга хэмжээ</p> <p>1. Сахилга баттай, хөдөлмөр, сургалтадүнэнчээрханддаг, ялтны сайн дурын байгууллагын ажил болон хүмүүжлийн арга хэмжээнүүдэд идэвхитэй оролцож буй хорих ял эдэлж буй ялтнуудад урамшууллын дараа харга хэмжээг авч болно.</p> <p>а/ талархал б/ бэлгээр шагнах в/ мөнгөн шагнал г/ нэмэлт илгээмж эсвэл гуйвуулга авахыг зөвшөөрөх д/ хүчингүй болсон¹ (2003.12.08-ны өдрийн Холбооны хуулиар №161) е/ түр эсвэл удаан хугацааны уулзалт авах эрх олгох ж/ хүнсний бүтээгдэхүүн ба нэн шаардлагатай эд зүйлсийг худалдаж авахад нь зориулан 500 хүртэл рублийг нэмж зарцуулахыг зөвшөөрөх з/ Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колоний² чанга дэглэмтэй нөхцөлд болон гянданд ял эдэлж буй ялтны гадаалах хугацааг нэг хүртэл сарын хугацаанд өдөрт 2 хүртэл цагаар уртасгах и/ урьд оногдуулсан шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах</p> <p>2. Колони-тосгонд ял эдлэж буй ялтанд урамшууллын арга хэмжээний хувиар амралтын болон баярын өдрүүдийг колони-тосгоны гадна өнгөрүүлэх явдлыг зөвшөөрч болно.</p> <p>3. Хүчингүй болсон³ (2010.04.05-ны өдрийн Холбооны хуулиар №46)</p> <p>4. Эерэгээр тодорхойлогдож буй ялтны цаашдын засрал хүмүүжлийн зорилгод нь нийцүүлэн ялын хугацааны хуульд заасан хэсгийг бодитойгоор эдэлсэн тохиолдолд хөнгөн ялаар сольж болно.</p> <p>114-р зүйл. Хорих ял эдлэж буй ялтанд урамшууллын арга хэмжээ хэрэглэх журам</p> <p>1. Талархалыг амаар эсвэл бичгийн хэлбэрээр, бусад урамшууллыг зөвхөн бичгийн хэлбэрээр зарлан олгоно.</p> <p>2. Урамшууллын журмаар нэг жилийн турш нэмж 4 хүртэл илгээмж эсвэл гуйвуулга авах, 4 хүртэл түр эсвэл удаан хугацааны уулзалт хийхийг зөвшөөрч болно.</p> <p>3. Энэ хуулийн 115-р зүйлийн 1 дэх хэсгийн “а”, “б”, 136-р зүйлийн “а”, “б”-д заасан шийтгэлийг ногдуулснаас хойш 3-аас багагүй сар, 115-р зүйлийн 1 дэх хэсгийн “г”, “д”, “е” хэсэгт заасан шийтгэлийг эдэлсэн өдрөөс 6-аас доошгүй сар өнгөрснөөс өмнө ногдуулсан шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгахыг зөвшөөрнө.</p> <p>4. Арилгагдаагүй эсвэл төлж дуусаагүй шийтгэлтэй ялтанд урамшууллыг зөвхөн урьд ногдуулсан шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах хэлбэрээр хэрэглэнэ.</p>

¹ Телефон утсаар ярих хугацааг нь нэмэгдүүлэх

² Цаашид “ЗХХК” гэх

³ Сахилга баттай ялтанд тэрчлэн энэ хуулийн 78-р зүйлийн 78.2, 87-р зүйлд заасан арга хэмжээг авч болно. (энэ нь дэглэм бууруулах явдал юм. Зохиогч)



119-р зүйл. Хорих ял эдэлж буй ялтанд урамшууллын ба шийтгэлийн арга хэмжээ авах ЗХХ-ийн байгууллагын албан тушаалтнууд

1. ЗХХБ-ын дарга эсвэл тэдгээрийг орлож буй этгээд энэ хуулийн 113, 115-р зүйлд заасан урамшуулал, сахилгын арга хэмжээг хэрэглэх эрхийг бүрэн хэмжээгээр эдлэнэ.

2. Отрядын дарга нар урамшууллын дараах арга хэмжээг авах эрхтэй:

а/ Талархал

б/ хүнсний бүтээгдэхүүн ба нэн шаардлагатай эд зүйлсийг худалдаж авахыг зөвшөөрөх

в/ Отрядын даргаас урьд оногдуулсан шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах.

3. Отрядын дарга нар амаар сануулах арга хэмжээ авах эрхтэй.

134-р зүйл. Хүмүүжлийн колонид хорих ял эдэлж буй ялтанд олгох урамшууллын арга хэмжээ

1. Сахилга баттай, хөдөлмөр, сургалтад үнэнчээр ханддаг ялтны сайн дурын байгууллагын ажил болон хүмүүжлийн арга хэмжээнүүдэд идэвхитэй оролцдог насанд хүрээгүй ялтнуудад энэ хуулийн 113-р зүйлд зааснаас гадна дараах урамшууллын арга хэмжээг хэрэглэж болно.

а/ тухайн колоний ажилтнуудын хамт хүмүүжлийн колоний гаднах соёл-үзвэрийн ба спортын арга хэмжээг үзэх эрх олгох

б/ эцэг, эх, тэднийг орлох хүмүүсийн эсвэл бусад ойрын төрөл садангийн хамтаар хүмүүжлийн колониос гадагшаа гаргах эрх олгох

в/ хүчингүй болсон⁴. (2005.04.01-ний Холбооны хуулиар №29)

г/ ял эдлэх чанга нөхцлөөс ердийн нөхцөл рүү хугацааны өмнө шилжүүлэх

135-р зүйл: Хүмүүжлийн колонид хорих ял эдэлж буй ялтнуудад урамшууллын арга хэмжээ хэрэглэх онцлог

1. Колоний ажилтнуудын хамт хүмүүжлийн колоний гадна гарч соёл-үзвэрийн ба спортын арга хэмжээ үзэх, эцэг, эх, тэднийг орлох хүмүүсийн эсвэл ойрын төрөл садангийн хамтаар хүмүүжлийн колониос гадагшаа гарах эрхийг урамшууллын хэлбэрээр эдлэж буй ялтанд өөрсдийнх нь иргэний хувцсыг олгоно.

2. Шөнийн цагаар явагдах соёл-үзвэрийн ба спортын арга хэмжээг үзэх явдлыг зөвшөөрөхгүй.

3. Хүмүүжлийн колониос гадагшаа гарах хугацааг тухайн колоний дарга тогтоох ба 8 цагаас хэтэрч болохгүй.

4. Ял эдлэх чанга (хатуу) нөхцлөөс ердийн нөхцөлд урамшууллын журмаар хугацааны өмнө шилжих явдлыг энэ хуулийн 114-р зүйлийн 4 дэх хэсгээр тогтоосон шаардлагуудыг сахиж чанга нөхцөлд 3 сараас доошгүй сар ялаа эдэлсний дараа зөвшөөрнө.

138-р зүйл. Ялтанд урамшууллын ба шийтгэлийн арга хэмжээ авах хүмүүжлийн колоний албан тушаалтнууд

1. Хүмүүжлийн колоний дарга болон тэдгээрийг орлож буй этгээд урамшуулал, сахилгын арга хэмжээг хэрэглэх эрхийг бүрэн хэмжээгээр эдлэнэ.

2. Отрядын дарга нар урамшууллын дараах арга хэмжээг авах эрхтэй:

а/ Талархал

б/ Хүнсний бүтээгдэхүүн ба нэн шаардлагатай эд зүйлсийг худалдаж авахыг зөвшөөрөх

в/ Хүчингүй болсон⁵. (2007.12.01-ний Холбооны хуулиар №299)

г/ Отрядын даргаас урьд оногдуулсан шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах.

3. Тасгийн хүмүүжүүлэгчид урамшууллын дараах арга хэмжээ авах эрхтэй.

а/ талархал

б/ тасгийн хүмүүжүүлэгчээс урьд ногдуулсан шийтгэлийг хугацааны өмнө арилгах

4. Отрядын дарга нар шийтгэлийн дараах арга хэмжээг авах эрхтэй.

а/ сануулах

б/ нэг сарын турш уран сайхны кино үзэх эрхийг нь хасах

5. Тасгийн хүмүүжүүлэгчид сануулах арга хэмжээ авах эрхтэй.

⁴ Сахилгын тусгаарлах байрнаас хугацаанаас нь өмнө гаргах

⁵ Телефон утсаар ярих нэмэлт эрх олгох



Энэхүү харьцуулалтаас үзвэл манай хоёр орны хууль тогтоомжийн хувьд дараах нийтлэг зохицуулалт байна. Үүнд:

1. Хорих ял эдэлж буй ялтанд олгох урамшууллын төрөл, хэмжээг төрөлжсөн хуулийн тодорхой зүйлийн хүрээнд хуульчилжээ.

2. Урьд ногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах явдлыг урамшууллын арга хэмжээний төрөл болгосон.

Ялгаатай зохицуулалтын хувьд:

1. Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 126-р зүйлээс үзвэл: “Хорих ангийн дэг журмыг чанд сахих, хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлж байгаа нөхцөлд ялтныг урамшуулах”-аар заажээ. Түүнчлэн ХЗДХ сайдын (хуучнаар) 2008 оны 50 дугаар тушаалаар баталсан “Хорих ангийн дотоод журам”-д: “Хорих ангиас зохион байгуулж буй ажилд идэвхитэй оролцож, зарласан болзлыг бүрэн хангасан, ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэмийг чанд сахиж, мэдлэг боловсролоо бие даан дээшлүүлсэн, шинэ санаачлага гаргаж хэрэгжүүлсэн”² гэсэн хоёр нөхцлийг нэмж урамшуулах үндэслэл болгон хуулийн зохицуулалтыг өргөжүүлсэн байна.

2. Манай орны хувьд урамшууллын нийтлэг арга хэмжээг 3 төрлөөр заасан бол ОХУ-ын Эрүүгийн ялын гүйцэтгэлийн хуульд нийтлэг 7 төрлөөр, мөн чанга дэглэмтэй нөхцөлд болон гянданд, түүнчлэн колони-тосгон, хүмүүжлийн колони хорих ял эдэлж буй насанд хүрээгүй ялтанд олгох урамшууллын онцлог хэлбэрийг тусад нь хуульчилж өгчээ.

3. Манай улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ялтны урамшууллыг хорих ангийн даргын шийдвэрээр тушаал гаргаж олгохоор тусгасан бол ОХУ-ын хувьд урамшууллын бүх хэлбэрийг ЗХХБ-ын дарга олгохын зэрэгцээ отрядын дарга талархал, хүнсний болон нэн шаардлагатай эд зүйлсийг нэмж худалдан авахыг зөвшөөрөх болон отрядын дарга³, тасгийн хүмүүжүүлэгчийн⁴ урьд ногдуулсан шийтгэлийг хугацаанаас өмнө арилгах эрхтэй байхаар хуульчилжээ.

² Журмын 21-р хэсэг, Ялтныг урамшуулах тухай

³ ОХУ-ын 119-р зүйл, 2 дахь хэсэг

⁴ 138-р зүйлийн 3 дахь хэсэг



4. ОХУ-ын хувьд хорих ял эдэлж буй ялтанд урамшууллын арга хэмжээг хэрэглэх журмыг⁵ Эрүүгийн ялын гүйцэтгэлийн тухай хуулийн хүрээнд нарийвчлан тодорхойлсон бол Монгол улсын хувьд сайдын тушаалаар журамласны зэрэгцээ асуудлыг шаардлагын түвшинд хүртэл нарийвчлан зохицуулаагүй байна.

Харин Монгол улсын хувьд онцолбол зохих нэгэн дэвшилттэй зохицуулалт бол “шагналын хоног” олгох явдал байгаа боловч цаашид уг харилцааны нарийвчилсан журмыг даргын эрх хэмжээнээс⁶ хуулийн түвшинд гаргах шаардлагатай.

ДҮГНЭЛТ

Хорих ялын эцсийн зорилго болсон нийгмийг хамгаалах, нийгэмд аюултай гэмт хэргүүдийг арилгах, урьдчилан сэргийлэх явдлыг хангахын тулд ялтан этгээдийг нийгмийн амьдрал, хуульд хүндэтгэлтэй хандан, өөрийн амьдралаа авч явах дадал хэвшилд аажмаар төлөвшүүлэх гэсэн хүн төрөлхтний нийтлэг хүсэл тэмүүлэл, хөгжлийн чиг хандлагыг иш үндэс болгон манай улсын хуулиар тогтоосон ялтны урамшууллын тогтолцоог өөрчлөх цаг болсон гэж үзлээ.

Тодруулбал: Урамшууллын арга хэмжээг ял эдэлж буй нөхцөл дэглэмтэй, ялтны насны онцлогтой нь уялдуулан ялгамжтай байдлаар олгох боломжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ нийгэмшүүлэх, иргэний амьдралтай хөл зэрэгцэн алхах чиглэлд түлхүү хандуулбал зохино. Тухайлбал: Хорих ангийн байрлалаас гадагш явах, түр болон удаан хугацааны уулзалт хийх, үзвэр-үйлчилгээ, соёл, спортын арга хэмжээг үзэх, оролцох боломжийг олгох, нэмэгдүүлэх зэрэг эрх зүйн орчинг бий болгож болох юм. Мөн урамшуулал олгох албан тушаалтнуудын хүрээг өргөтгөх шаардлагатай.

⁵ 114-р зүйл

⁶ ЦШПГЕГ-ын даргын 2010 оны А/73 дугаар тушаал “Ялтанд шагналын хоног олгох, тэнсэн суллах, ялыг дэглэмийг өөрчлөхөд мөрдөх журам”